

## ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 01 ДУГААР САРЫН МЭДЭЭ

### **Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэний гаргасан гомдол барагдуулах, гарсан зөрчил дутагдлыг таслан зогсоох үйл ажиллагааг томилогдсон ажиллалаа. ХХААХҮ-ийн яамнаас ажлын байрыг нэмэгдүүлэх, Жижиг дунд үйлдвэрлэл Сумын Засаг даргын 2023 оны А/08 дугаар захирамжаар Монгол улсын Тамхины эрхлэгч нарын нөхөрлөл, хоршоо байгуулах, үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөх зорилгоор Төрийн банкаар дамжуулан олгож буй 4.4 хувийн хүүтэй зээл, Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах тоног төхөөрөмийн зээлийн зарыг иргэдэд шуурхай хүргэж ажиллаж байна. ЗДТГ-н 30-н албан хаагчийн УБ хотод аваачин эрт илрүүлэгт хамрууллаа. Сумын Аварга адуучин тэмцээнийг Уяачдын холбоотой хамтран 3-р багийн нутаг Далай булагт амжилтай зохион байгуулсан. ХХТХ-ний хурлыг 0146-р ангитай хамтран 1, 2-р заставт хилийн туслах хүчний 20 гишүүдтэй хамтран хийж гурвалсан гэрээ байгуулав

**Нийгмийн даатгал:** 2023 оны 01-р сарын ААН, Б-н 64 харилцах, тайланг 01.05-ны дотор хугацаанд нь цахим болон цаасаар тайлагнаж байгууллага тус бүрээр нь тайлагнасан. 2023 онд А/О-с, СДД, ЭМД-аас орох орлогыг төлөвлөгөөний судалгааг гаргаж аймгийн НДХэлтэст хүргүүлсэн. ЭМД-д 71 иргэний 4889,0 мянган төгрөг, СДД-д 142 иргэний 15120,4 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаа. 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550 000 төгрөг болсонтой холбогдуулан ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛ болон Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод групп дээр мэдээлэл сурталчилгаа хийж Нийгмийн даатгалын шимтгэлийн өөрчлөлтийг сурталчилан ажиллаа. Шинэ тэтгэвэр 3, тэтгэмж 23 тус тус хүлээн авч шийдвэрлэн ажилласан

**ЕБС:** 2023 оны 01 дүгээр сараас эхлэн элсэлтийн ерөнхий шалгалтын давтлагыг хуваарийн хичээллүүлж байна. 1 дүгээр сард “МӨНГӨН ГҮҮР” эмнэлэгт 51 багш ажилтанаа эрт оношилгоо үзлэгт хамруулсан. Дунд ангийн багш нарт гүйцэтгэлийн үнэлгээ болон ухаалаг дэлгэцийн талаарх мэдээлэл, web хуудас хийх аргачлалын сургалтыг дундын 35 багш нарт явууллаа. Нийт багшийн 80 хувь нь модуль сургалтандаа амжилттай хамрагдаж ажлын байрандаа тасралтгүй хөгжиж байна. Хүүхэд хамгаалалын асуудал сэдвээр 65 багш ажилчдад сургалт зохион байгуулж багш ажилчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.

Боловсролын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх IV сургалтын талаарх мэдээлэл, БШУС-н 12 дугаар сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт ЕБС-н багш ажилчид “ЁС ЗҮЙН” журмыг танилцууллаа.

**Соёлын хүрээнд:** Номын сангаар ирж үйлчлүүлэгчийн тоо-14, Шинээр карт нээж үйлчлүүлэгчийн тоо-4 нийт 18 уншигчдад үйлчилгээ үзүүлж, гэрээр 39 ширхэг

ном олгон ажиллалаа. 2023 оны 1 дүгээр сарыг байгууллагын хүрээнд төлөвлөлтийн сар болгон албан хаагчид бүр сар, улирал жилийн ажлын тайланг төлөвлөн батлуулж ажиллалаа.

Соёл урлагийн газраас ирсэн-4, ЗДТГ-аас ирсэн-1 бичиг баримтыг хүлээн авч соёлын төвийн даргад тухай бүрт танилцуулан хариутай 3 мэдээний хариуг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

2023 онд зохион байгуулагдах үйл ажиллагааны саналыг иргэдээс цахимаар болон цаасаар судалгаа авч яамны бодлогын баримт бичиг, системийн байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх бэлтгэл ажлыг эхлүүлж байна.

**“Эрдэнэцагаан нутгийн авьяаслаг залуу уран бүтээлчид”** МУСТА, С.Баторших, С.Хүрэлбаатар, Б.Ширмэнбаатар нар нь 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Талархал” хамтарсан тоглолтоо нутгийн зон олондоо толилуулахаар тоглолтын бэлтгэл ажлыг соёлын төв дээр хийж байна.

#### **Байгаль орчны чиглэлээр:**

Цаг агаар их хүйтэрч байгаатай холбогдуулж зэрлэг ан амьтдын өвөлжилтын байдалыг үзэж хархаар сумын засаг даргаар ахлуулсан ажлыг хэсэг Буга, Цагаан зээр байрлах Лхачинвандад, Хэцүү, Бугын аман ус зэрэг газруудад ажиллаа. Хадан хөвөө гэх газар үхсэн 3 бугын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулж, эвэр толгойг нь сумын үнэлгээ тогтоох орон тооны бус зөвлөлд хүлээлгэж өгсөн байна. Сумын засаг дарга болон газрын даамал, тухайн багийн засаг дарга нартай хамтарч Эрдэнийн босго ххк-д хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, орон нутагтай байгуулсан гэрээ байхгүй, газрын төлбөрөө төлөөгүй, шавхалтын ус тоолуур байхгүй гэх зэрэг зөрчилүүдийг илрүүлж хугацаат үүрэг даалгаврыг өгч ажиллаж байна.

#### **Албан хэрэг, архив хөтлөлтийн ажлын хүрээнд:**

Засаг даргын захирамж А/8, Тамгын газрын даргын тушаал-2, Албан тоот -56, Ирсэн бичиг 27 хүлээн авч хариутай 4 бичгийн хариуг холбогдох газарт явуулсанд хяналт тавьж ажиллалаа. 2023 оны нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд 14 хадгаламжийн нэгжийг архивт татаж төвлөрүүлж мөн 4 иргэнд Малын А дансны лавлагааг гарган өгч ажиллаа. Мөн 2023 оны 01 дүгээр сардаа багтаан Багийн Засаг дарга нараас малын А данс, мэргэжилтэнгүүдийн баримтыг Архивт татах ажилд бэлтгэн төлөвлөж хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу ажиллаж байна. Алдарт эхийн одонтой холбогдуулан 2 дугаар одонгийн материалыг 5 иргэнээс хүлээн авч бүртгэл үйлдэн ажиллаж байна.

#### **Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:**

[Erdenetsagaan.su.gov.mn](http://Erdenetsagaan.su.gov.mn) вэб сайтанд тушаал журам, цаг үеийн мэдээллийн талаар нийтэлж ажилласан.

“Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.

#### **E-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:**

| Д/д  | Үйлчилгээний тоо |           |           | Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ                                  |     |
|------|------------------|-----------|-----------|-------------------------------------------------------------------|-----|
|      | Нийт             | Төлбөртэй | Төлбөргүй | Нэр                                                               | Тоо |
| 1    | 11               |           | Төлбөргүй | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт         | 38  |
| 2    |                  |           | Төлбөргүй | Иргэний үнэмлэхийн лавлагаа                                       | 9   |
| 3    |                  | 134.890   |           | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар                         | 2   |
| 4    |                  |           | Төлбөргүй | Иргэнд олгох тодорхойлолт                                         | 6   |
| 5    |                  | 3.500     |           | Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт | 8   |
| 6    |                  |           | Төлбөргүй | Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах                             | 12  |
| 7    |                  |           | Төлбөргүй | Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа                                     | 1   |
| 8    |                  |           | Төлбөргүй | Гэрлэсний бүртгэлийн лавлагаа                                     | 3   |
| 9    |                  |           | Төлбөргүй | Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа           | 4   |
| 10   |                  |           | Төлбөргүй | Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа                           | 1   |
| 11   |                  |           | Төлбөргүй | Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа                                      | 2   |
| Нийт |                  | 2         | 9         |                                                                   | 86  |

И-Монголиа системээр иргэдэд 11-н нэр төрлийн 86 лавлагаа үйлчилгээ үзүүлж 138.390 төгрөг төвлөрүүлсэн байна.

#### **Erp.e-mongolia.mn Төрийн байгууллагуудын цахим системийн хүрээнд:**

Аймгийн мэдээллийн технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн Ц.Гэрэлт-одтой ярьж [erp.e-mongolia.mn](http://erp.e-mongolia.mn) сургалтыг явуулж байгууллагын албан хаагчдыг цахим сургалтанд хамруулсан.

ЕБСургууль, Соёлын төв, 1, 2 дугаар цэцэрлэгт сургалт хийж QR кодоор цаг бүртгэж, систем ашиглалтыг сайжруулах, арга хэмжээг авч ажиллаж байна.

#### **Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

Мал тооллогын ажлыг амжилттай зохион байгуулж 476813 толгой малтай болж 4-н төрөл дээрээ өссөн байна. Тэмээ 24 толгойгоор буурсан. Багуудаас ирсэн судалгаагаар гадны өөр аймаг сумдаас 19 өрх 17650 толгой мал ирж өвөлжиж байна. Малдад хээлтүүлэгчийг цаг хугацаанд нь сүрэгт нийлүүлэх, багийн засаг дарга нарт отроор явж байгаа өрх айлын судалгааг мал эмнэлгийн байгууллагаас авах, мал эмнэлгийн бичгийг үндэслэн отор нүүдэл оруулах шаардлага тавьсан.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.